

ТОГТООЛ

УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРГААНЫ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН 1, 2, 3 ХУРЛЫН ТОГТООЛ, ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН 1, 5-Р ХОРООНЫ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 3, ЗАХИРГААНЫ ЗӨВЛӨЛИЙН 1, 4, 14 ХУРЛЫН ТОГТООЛ, ГАДААДЫН ПҮҮС ХОРООДООС ТАТВАР НООГДУУЛСАН КОМИССЫН ТОГТООЛ

УЛААНБААТАР ХОТЫН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН НЭГДҮГЭЭР ХУРЛЫН ТОГТООЛ

Монгол улсын арван зургаадугаар он зургаан сарын хорин наймны өдрөө харьяат Улаанбаатар хотны төлөөлөгч дөчин таваас хуралдсан нь 32 болох учраа уул хурлыг нээж хэлэлцсэн нэгдүгээр хурлын тогтоол

Нэг. Тус хурлын дарга ба нарийн бичгийн дарга нар энэ хэр чөлөөтэй учраа энэ өдрийн хурлын дарга ба нарийн бичгийн дарга нарт хэн хэнийг сонгохыг хэлэлцээд даргад Дарьжав нарийн бичгийн даргад Мишигдоной нарыг тус тус сонгов.

Хоёр. Тус захиргааны газрын товчооноос орон гарсан даргын орныг сонгуулъя хэмээснийг илэрхийгээр хэлэлцээд даргад даргад Батсүх, орлогчид Рагчаа нарыг тус тус сонгон баталсан явдлыг хотын захиргаанаас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Гурав. Мөн товчооноос нэгэн жилийн хугацаа дууссан хороодын төлөөлөгч ба тус захиргааны газрын гишүүдийг хэрхэн сонгуулах тухайг хэлэлцүүлэе хэмээснийг хэлэлцээд чингэж сонголт үйлдэж гүйцэтгэх нь зүйтэй тул даруйхнаа харьяат захиргааны газраас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Дөрөв. Харьяат газрын албан хаагчдын нэгдүгээр хурлын дөрөвдүгээр зүйлд тус газрын товчооноос эдүгээ аж ахуйн яамнаас манай захиргааны газраас эрхлэн байгуулсан мөн яамны баруун этгээд дэх цэцэрлэгийг мөн газрын баруун залгаа буй дэлгүүрүүдийн газрын хамт харилцан хороонд шилжүүлэн олгуулах явдлыг түүгээр хэлэлцэн гүйцэтгэмү хэмээн илгээн ирсэн нэгэн хэрэгт манай товчооноос чингэж шилжүүлэн өгөх ахул уул байгуулсан сүйтгэлийн үнийг авч бусад хүчин төгөлдөр болоогүй цэцэрлэгүүдийг сайжруулбаас зохих мэт учраа уг саналыг илэрхийлж тэдний эрхлэгчид лүгээ харилцсан боловч чухам чингэсүгэй хэмээх оновчтой шийдвэр гаргаж тогтсонгүй дэмий л шилжих шилжүүлэх явдлыг шаардан буй нь одоо хэрхэн харилцаж өгч авалцваас зохихыг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд одоо аваас тус захиргааны газрын эрхлэн сайжруулах цэцэрлэг хэд хэд болох бөгөөд энэ завсраа сан хүү нэмсэнд гачигдан төдий л гүйцэтгэн сайжруулж чадаагүй боловч энэ жилд эрхиш хүчин төгөлдөр болгохыг оролдон буйн дээр эл зүйлд мөн ч нэлээдхэн төвөгшил, мөнгө орсон болох нь одоо чингэж шилжүүлэхэд алсын ашиг гарз эдүгээгийн үнэ зүйл хэрхэн болохыг урьдаар тусгай комисс гаргаж харилцан туслалцах хоршооны зэрэг газар лугаа хамт нийлж элдвийг ярилцан хэлэлцүүлж, хотын төлөөлөгчийн хурлаас өмнө хэрхэх саналыг тодорхойлон гүйцэтгүүлбээх болов уу хэмээн мөн комисст

сургагч Паргас, гишүүн Жигмэд нарыг томилж мөн комиссын хэлэлцээр саналыг эрхлэх товчооноос хянан хотын хуралд хэлэлцүүлэхээр тогтов хэмээснийг хэлэлцээд тэрхүү байгуулсан цэцэрлэгийг хэвээр сайжруулан явуулах ахул шууд шилжүүлэн өгвөөс зохимуй хэмээн тогтов.

Тав. Мөнхүү хурлын тавдугаар зүйлд тус товчооноос сая аж ахуйн яамнаас цагаан сүмийн өмнөх цэцэрлэгийг урьд тогтоолын ёсоор хамгаалан засацгааж гүйцэтгүүлэхээр тушаасныг дагаж тус товчооноос давыг эрхлэн мөнхүү цэцэрлэг газрыг төмөр утсаар хайсалж, энэ удаа хүрэлцэж бололцохыг гэрчүүлэн \гэрчлүүлэх\ цагдан харгалзагч хүн гурав бас аливаа зугаацахаар очигчдод пиу үнэмлэх олгож зөвхөн зохисын үнэ хураах байцаах нярав бичээч нэгэн орныг томилон гаргаж суулгахаар төлөвлөн явуулсан нь одоо уг утас ба шон модны үнэ мөн үйлдвэрлүүлэхийн хөлстэй нийлж 1727 төгрөг 85 мөнгө болсныг банкинд үржүүлэн хадгалуулсан цэцэрлэгийн зүйлээс гүйцэтгэсээр болохын дээр тэдний зугаалахаар очих аливаа хүмүүст найман цагийн хэмжээгээр бөгөөд хүн тутам хорин мөнгө, улаан цэрэг ба арван таван наснаас доош хөвгүүдэд арван мөнгөний үнэтэй пиу олгуулах мөн нэгдүгээр хоол ундны зэрэг худалдаа хийх учир дам хөлслөн авах эрмэлзэх хүн буй үгүйг зарлал гаргасан нь энэ завсраа үйлдвэрчний албан хаагчдын товчоог чингэж хөлсөөр үйлдвэрлэхийг хэлэлцэхээр ирсэн лүгээ харилцаж эцэслэн тогтсон сар бүр 101 төгрөгний хөлс авч зүй зохисын худалдаа хийлгэхээр гэрээ байгуулахыг завдан буй ба мөн харгалзагч морьтой хүн тутам сар бүр 45 төгрөг, нярав бичээчид 55 төгрөгний цалин олгуулахаар тогтоож энэ удаа тухайн мөнгө ба орлогын зүйлээс тавин олгуулж орлого зарлагыг тусгай дансаар явуулан дангаар хүрэлцэх эсэхийг үзэж өөр гүйцэтгэн шийтгүүлбээс нийлэлцэх эсэхийг хамтаар хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд энэхүү цэцэрлэгийг энэ мэт хамгаалан харгалзахуй нь зүйтэй бөгөөд энэ удаа аль бүрийг харгалзан эл төлөвлөн явуулсан ба явуулахуйг завдан буй төлөвлөсөн зүйлүүд нийлэмжтэй гагцхүү хүн тутам найман цаг зугаацуулахад эрхбиш шөнийн цагийг оролцуулахгүй болгон басхүү зугаацагчид ба худалдаачдад хэрэглэх архины зэрэг хоорлолтой зүйлийг хэмжээтэйгээр хэрэглүүлэн байлгаваас зохихыг харгалзагчдад сайнаар даалган гүйцэтгүүлбээс зохих ба бусад зүйлийг товчооны төлөвлөсөн ёсоор гүйцэтгүүлбээс зохих болов уу хэмээхийг хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн батлуулж гүйцэхгэх явдлыг хуралд хэлэлцүүлэхээр тогтов хэмээснийг хэлэлцээд эл зугаацахаар одогчдын элдэв хэрэглэлийг харгалзагч гурван хүнээс нэгийг хасаж хоёр болгож уг цэцэрлэгийн газрыг сайнаар ариутган сайжруулах ба бас нярав бичээч нэгийг хэвээр бүгд гурван орон болгож мөн тус хотны зугаацагчдын дотор олон сургуулийн хөвгүүд охидыг арван мөнгөөр зугаацуулан үзүүлэхээр хэлэлцэн тогтож эл учрыг зохих газраа явуулан гүйцэтгүүлэхээр тогтов.

Зургаа. Хурлын зургаадугаар зүйлд мөнхүү товчооноос хотын дүрэмд заасан ёсоор харьяат хотын ариун цэвэр болгон сайжруулахад гагцхүү тус хотын доторх газар газраа тархан суусан ногоочин, шаварчин, мужаан нарын новш буртаг үлэмж бөгөөд эрхгүй хотын гадна тусгай газраа нийлэлдүүлэн суулгаваас сая зохих болох учраа аль бүрийн дөхөм тусыг бодож, Амгаланбаатар хотноо шилжүүлэн нийлэлдүүлж, суулгахаар тогтоож зохих газуудад ноднин жил есөн сараас эхлэн тушааж шаардан буй атал саяхан аж ахуй хянан байцаах яамдаас эдүгээхийн үйлдвэр үлэмж үест эл мужаан шаварчин нарыг чингэж шилжүүлэн суулгахуй нь нийлэлцэхгүй хэмээхээр санал гаргаж ирүүлсэн учраа уг хэргийг хэвээр

хүлээлгэн буй тул чухам хэрхэн болгон гүйцэтгэн шийтгүүлбээс зохихыг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснээ энэ мэт хог буртгийг үйлдвэрлэх этгээдийг эрхиш тусгай газар нийлэлдүүлэн суулгаж хот хороог ариун цэвэр болгохуй нь нэн чухал. Хэдийгээр үйлдвэр үлэмж үест үл нийлэлцэх хэмээвч албан ба ардын аливаа барилга ба үйлдвэр барьж төгсөхүй нь бэрх тэр бүрийг хүлээж хог буртагт хэвээр хольцолдон байхул хотыг ариун цэврээр засан сайжруулах замд нэгнээ сааталтай болох төдийгүй заавар дүрэм ёсоор хоёрдоход хүрэх тул одоо учир иймд урьд шийдвэрийн ёсоор гагцхүү газрын бололцоохыг зохих газар лугаа харилцан зөвлөж шууд шилжүүлбээс зохих авч одоо аваас эл үйлдвэрчний элдэв ажил энэхэр нэгэнт хөдөлж бүхий цаг болохын дээр ялангуяа ядуу ногоочинд сэлтээс хохиролтой зүйл үлэмж болж ардын амьдралыг алдагдуулахад хүрэх газар бүхий мэт тул энэ жилд онц харшдахгүй газраа буйг нь хэвээр суулган эсэргүүн хаврын тэргүүн сараас эрхиш бүрнээ тусгай газраа тус тус заан олгож шилжүүлбээс зохих болов уу хэмээхийг хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд тэдний мод шороо ногоочны үйлдвэрчин хэдэн хүмүүсийг ялган салгаж суулгахуй нь чухам тул эсэргүүн жилийг татаж энэ он намар өвлийн завсраар уул хэлэлцсэн ёсоор ялган салгаж суулгахаар хэлэлцэн тогтсон учраа зохих газраа явуулж байцаан толилуулж батлан тогтоолгохоор хэлэлцэн тогтов.

Долоо. Мөн хурлын долоодугаар зүйлд товчооноос цагдан сэргийлэх хэлтсээс үүний урьд биллъярд хэмээх бөмбөг наадах эрхийг олсон спартак хэмээх бүлгэмийн газрыг дотоод яамны тушаасан ёсоор мөрийцөн наадуулах мөлжин хохируулж үл болох учрыг уламжлан олгуулах гаргаж удаа дараа тушаасаар атал огт хэрэгсэхгүй агсаар эдүгээд хүрч эл хэргийн учраа заалдан тэмцэж явагчид цөөхөнгүй болжээ. Үүнд хянаваас энэ мэт бөмбөгөөр наадах эрхийг чингэж гадаадын хүмүүст өгч түмэн ардыг хохируулан бүхий нь үнэхээрийн нийлэлцэхгүй учраа одоо тэрхүү бөмбөгийг тэдний эрхээс шууд хураан авч уш хэрэгслийг Сүхбаатарын төв клубын газраа шилжүүлэн тухайд цаг хэмжээ тогтоон мөрий хөлсгүйгээр олон ардыг наадуулбаас болох болов уу хэмээснийг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд эл хэргийг тус хэлтсийн төлөвлөсөн ёсоор төв клубын газраа шилжүүлэн эрхлүүлэх нь зүйтэй болох тул хотын хурлаар тогтоолгон гүйцэтгүүлэх явдлыг хуралд хэлэлцүүлэхэд хөнддөг хэмээснийг хэлэлцээд харьяат хотны дотор олон наадагчдыг тийнхүү клубт эрхлүүлэе хэмээсэн нь үл зохилдох тул хэрвээ гадаад улсын хүн наадах аваас тухайд хянан гүйцэтгэх ба тус монголын доторх монголчуудыг хэзээ ямагт чангалан цаазалбаас зохимуй хэмээх зэргээр хэлэлцэн тогтож харьяат захиргааны газраас эрхлэн зохих газар лугаа харилцан гүйцэтгүүлэе хэмээн тогтов.

Найм. Мөн хурлын наймдугаар зүйлд товчооноос мөнөөхөн дотоод яамнаас уламжлан засгийн газраа ба нам эвлэлийн төв хороодоос санал гаргаж шаардан тушаасан ёсоор тус захиргаанаас эрхлэн олны бие угаах ихээхэн хэмжээний байшин бариулж ванн гаргахыг хичээнгүйлж эл тухайн зардлыг бараглан төсөвлөвөөс даруй зургаан түмэн шахам төгрөг болох бөгөөд одоо энэхэр тус газрын орлого хомс олж хураасан мөнгө үгүйн дээр басхүү бариулсан ба бариулж байгуулахыг завдан буй барилгын зүйл нэлээд учир аль бүрийг аривлан хэмнэж чухалчлан үзэж бүрнээ гүйцэтгүүлэхийг санаа бие чармайвч сан хүү үгүйд саатагдан боогдож алгуурлагдах нь хэрхэх аргагүй мухардах үүнд эл ванн байгуулахуйд тус газрын мөнгө хүрэлцэхгүй зүйл гарах ахул тухайд хянан хэлэлцэж гүйцэтгэвээс зохимуй

хэмээхээр засгийн газраас тушаасан зүйл буй болоход санаа эрчин хянаваас энэ мэт албаны ванн байгуулан ариун буртгийг ялгаруулан ардын эрүүлийг хамгаалах ба аливаа гадаадын идэмхий нарын буртагт бузарлагдан мөлжигдөхгүйг эрхлэн бүхий эл хэрэгт эрхбиш туслах зорилготой тусгай орлого бүхий албан худалдааны газруудаас онц тусламжийг гуйж, дутагдахыг тус улсын банкнаас зээлдэн авч нэн даруйхнаа идэвхийлэн гүйцэтгүүлбээс юун болов хэмээхийг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд эл бие угаах ванныг ийнхүү чухалчлан байгуулахуй нь зүйтэй гагцхүү хэрэгсэх мөнгийг чингэж тусгай орлого бүхий газраас тусламж гуйх хэмээснийг энэ удаа түтгэлзэн дан ганц банкнаас урьдчилан авч даруй гүйцэтгүүлэхийг хичээвээс тав тув болох болов уу хэмээхийг хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн тогтоолгох явдлыг хуралд хэлэлцүүлэхээр тогтов хэмээснийг хэлэлцээд ийнхүү бие угаах газрыг даруй үйлтгүүлж олон ардыг сайжруулан хамгаалах нь зүйтэй тул харьяат хурлын төсөвлөсөн ёсоор мөнгө зээлдэх явдлыг зохих газар лугаа харилцан тухайд боогдол сааталгүй болгон бэлтгүүлэх явдлыг харьяат захиргааны газраас нэн даруйхнаа завдан гүйцэтгүүлэхээр тогтов.

Ес. Мөн хуралдааны есдүгээр зүйлд мөнхүү товчооноос үүний урьд тус захиргааг нээн байгуулж харьяат хотын ардуудыг хол ойрыг үзэж бүгд арван таван хороо болгон хороо тутам дарга бичээч, зарлага нэгжгээд орныг байгуулан захируулж дагаж шийтгүүлэн бүхий үүнд байцааваас эл зохиогдсон хороодын зарим нь өрхийн тоо нэн цөөн, нэр төдий болон дэмий л цалин хэрэглэлийн сүйтгэл болохоос өөр тусыг олох газаргүйн дээр харьяат хороодын дарга бичээчийн зэрэг албан хаагчдад олгох цалин хомс, хүн ховрын харгайгаар уг тушаалыг тусгай албатай хүнд хавсаргах буюу огт бичиг хэрэг төсөвлөхгүйг нь ор нэр болгон хаалгаж оролдох тушаалын хэргийг орхигдуулан чухлыг алдагдуулахад хүрч бүхий бөгөөд тушаалын хэргийг бүтээн чадахыг тус тус сонгууль хэмээх авч тусгайлан олгох цалин хэрэглэл нэн хомс, нэмэгдүүлье хэмээвч тус газрын сан хүү нимгэн орлого бага тул одоо зүй нь эл хороодын эрхбиш ойр харьяагаар нийлүүлэн цөөтгөж, албан хаагчдын орон тоо цалин хэрэглэлийг нэмүүхнээр тогтоолгож, албан давхарлуулахгүй болгон дагаж шийтгүүлбээс болох эсэхүү ба хэрвээ болохул аль аль хороог нийлүүлэн хичнээн хороо болгох ба орон тоо цалин хэрэглэлийг хичнээнээр тогтоож явуулбаас болохыг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд эрхлэх товчооноос ийнхүү илэрхийлэн гаргасан нь үнэнтэй бөгөөд эрхбиш чингэж цөөтгөн тогтоохуй нь элдэвт зүйтэй болох тул ёсоор болгон явуулбаас зохих үүнд нэгдүгээр хоёрдугаар хороодыг нийлүүлэн нэгдүгээр хороо, гуравдугаар, дөрөвдүгээр, тавдугаар хороодыг нийлүүлэн хоёрдугаар гуравдугаар хороо, 6, 7 дугаар хороодыг дөрөвдүгээр, тавдугаар хороод болгон хэвээр наймдугаар есдүгээр хороодыг нийлүүлэн зургаадугаар хороо, аравдугаар, арван хоёрдугаар хороодыг нийлүүлэн долоодугаар хороо, арван нэг, арван тавдугаар хороодыг нийлүүлэн наймдугаар хороо арван гуравдугаар, арван дөрөвдүгээр хороодыг нийлүүлэн есдүгээр хороо хэмээн бүгд есөн хороо болгон тус тус ийнхүү нэрийдэх ба мөн хороо тутам дарга, бичээч, зарлага нэгжгээд орныг хэвээр бөгөөд даргад 70 төгрөг, бичээчид 55 төгрөг, зарлагад 45 төгрөгний цалинг бичгийн хэрэглэлийн хамтаар тавин олгуулбаас төдий л алсглагдах ба дутагдаж мөхөстөх зүйл үгүй, харин ч үлэмжхэн зарлага хомстож алин бүрт тустай болов уу хэмээхийг хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд арван таван хороодын тоог цөөтгөх нь зүйтэй тулд харьяат хурлын төсөвлөсөн ёсоор ханган татаж

гагцхүү тэдний албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхийг хэрэгсэхгүй болгох явдлыг тус эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Арав. Мөн хурлын аравдугаар зүйлд товчооноос тус хотын доторх ажилгүй золбин нохойд зэрлэгшин догширч хүн малын амийг бусниулан сүйтгэх болсон ба хотыг ариун цэвэр болгох хэрэгт үнэхээрийн боогдолтой болох учраа тус товчооноос эдгээр ажилгүй нохойдыг барьж тусгай нэгэн газар хашиж тэжээлгэх ба ажилтай нь дугаарлан тэмдэглэж зохисын татвар хураахаар төлөвлөн мөн хашааг худалдан авах тусгай комисс томилон гаргаж байгуулах газрыг заан олгосон нь энэхэр олон уг хашаа төлөв гүйцэхүйд хүрсэн бөгөөд эл хашааг сахин харгалзаж сайнаар байгуулахүйд гурван хүнийг томилон суулгаж мөн нэгэн түүгээр барих тэрэг, морь нохой хооллох тогоо хувин зэргийг бүрнээ худалдан авч үйлтгүүлж бүхий бүгд зарсан төгрөг 3275 болсноос гадна эл зүйлийг ийнхүү явуулсан нь нийлэлцэх эсэх хэрвээ зүйтэй ахул мөн газрын төсөвлөсөн дансыг даруй үйлтгүүлж зохих газраа мэдүүлэн батлуулахын дээр энэхүү нохойдыг чингэж хорихүйд аливаа үхэгсдийн хүүр далдлагдахгүй өмхийрөн олшрох агаад эл хүүрийг тусгай газар заан олгож уг журамтайгаар тухай бр гүн далд газар оршуулах зэргээр дагаж явуулах ахул аливаа гэм хор ариудан цэвэршихэд идэвх дөхөм тустай болох болов уу хэмээхийн тул эл учрыг илэрхийлэн гаргаж хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд эл золбигаасан /золбин/ нохойдыг хорьж тэжээлгэх ба ажил бүхий нохойдод дугаар пайз олгох зохисын татвар хураахуй нь зүйтэй бөгөөд ёсоор болгон төсөвлөсөн дансыг эрхлэх хэлтсээс даруй гүйцэтгүүлэх ба гагцхүү үхэгсдийн хүүрийг хэрхэн оршуулах явдлыг хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд гагцхүү нохойдыг товчоо ба хурлын төлөвлөсөн ёсоор завдаж гүйцэтгүүлэх явдлыг тус захиргааны газраас идэвхийлэн гүйцэтгэх ба хүний хүүрийг энэ удаа хуучин хэвээр гээж нэгэнтээгүүр зохих газраа мэдүүлэн явуулж тогтоон заалгахыг эрэхээр тогтов.

Арван нэг. Мөн хурлын арван нэгдүгээр зүйлд товчооноос үүний урьд тус захиргааны газрын энэ арван зургаадугаар оны зарлагын төсөвлөсөн дансыг үйлдэж хотын төлөөлөгчийн долоодугаар хуралд батлуулан тогтоолгож уламжлан дотоод сангийн явдлын яамнаа батлуулахыг эрж мэдүүлсэн дараа цалин хэрэглэлийг тавин олгох зарцуулан хэрэгсэх хэрэг тохиолдсон учраа тухайд сангийн явдлын яамнаас эл төсөвлөснөөр явуулж болох эсэхийг ам лавлуулсанд төсөвлөсөн ёсоор явуулахүйд татгалзахгүй хэмээснийг баримтлан энэ завсраа цалин хэрэглэлийн зэрэг элдэв алгуур, түргэн ба зарлагыг боогдуулж болохгүй учирт эдүгээ таван сар илүү болтол тавин олгох зэргээр зарцуулсаар атал сая тодоод яамнаас уламжлан сангийн яамнаас уг төсөвлөсөн дансны доторх нэгдүгээр цалингийн зүйлийг засгийн яамдын адил зэрэг дугаараар төсөвлөсөн нь нийлэлцэхгүй бөгөөд хэрхэвч аймгийн дүрмээс ангид болгох зүйлгүй тул хуучин хэвээр хангавай хэмээхээр тушаан хүрч иржээ. Үүнд хянаваас харьяат Улаанбаатар хот болбоос олон овгийн арав шахам түмэн ам ард иргэн хольцолдон суусан Монголын охь манлай орон болох бөгөөд тус захиргааны газрын үүрэглэн гүйцэтгэх элдэв албан хэрэг идэвх хүнд албан хаагчид ховордон олдохгүй албан хэргийг алдагдуулахад хүрч бүхий байдлыг бэлхнээ тайлбарлан тодорхойлосон тул дахин нуршиж давхарлах юун. Гагцхүү дээд газраас энэ мэт аймгийн нэгэн адил болгон тогтоохүйд даанч хот хөдөө ба албан үүргийн хүндийг огт ялгаварлан үзсэн явдалгүй урьд нэгэнтээ тухай цагт нийлүүлэн хянаж тогтоосноо

баримтлан ийнхүү хассан нь гарган хэмнэхийг урьтал болгосноос бус хэргийн явуулалгыг хэрхэг болгохыг толилсон нь тодорхойгүй боловч дээд газраас толилцгоосон хэрэг буй ял хэмээн дуугай дагаж загуулбаас зохих агсан гэтэл харьяат албан хаагчид цөм бус аймаг хошууны хүн болох ба бас ч хааяа нь өөр газраа цалин хэрэглэлийн нэмүүхнээр шилжиж алба хаасугай хэмээн явцгаахыг эрэлхийлэх бөгөөд шууд явуулахад татгалзалтай боловч хүчлэн саатуулах зүй олохгүй болж буй тул чухам хэрхэн болговоос зохихыг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд эл төсөвлөсөн дансыг анхнаас дээд яамдын зэрэг дугаараар хэрчүүлэн төсөвлөж мэдүүлсэн нь албан үүргийн хүнд аль бүрийг хянаж бодсоноос бус чингэж үлэмжхэн мөнгө авах хэрэглэхийг хичээсэн зүйлгүй багахнаа тийн бөгөөд харьяат хотын төлөөлөгчийн хурлаас хянан баталж явуулсан хэрэг болов уу хэмээхийн дээр харьяат албан хаагчид хэдийгээр засгийн албан хэрэгт үнэн санаагаар бие чармайн зүтгэхийг хичээгүүлэх авч амуу цалин шүтэж амьдарахуй нь туйлын бодлого болох тул хасаж тогтсон цалин амууг шүтэж энэхүү газраа тус тусын албан үүргийн ялыг хүлээж чадахгүйд хүрч өөр шилжих буюу аж зуул эрэх хэмээх нь илэрхий болох тул энэхүү цалинг эрхбиш уул төсөвлөсөн ёсоор батлуулахыг хотын төлөөлөгчийг хуралд дахин хэлэлцүүлж тогтоолгоё хэмээснийг хэлэлцсүгэй. Энэ нь төлөв үнэнтэй бөгөөд хотыг сайжруулах хэрэгт боогдол гачигдал болох учир эрхбиш урьд тогтоол ба хурлын төсөвлөсөн ёсоор болгож зохих газраа мэдүүлэн явуулж батлан тогтоолгох хуралд дахин хэлэлцүүлж тогтоолгоё хэмээснийг хэлэлцсүгэй. Энэ нь төлөв үнэнтэй бөгөөд хотыг сайжруулах хэрэгт боогдол гачигдал болох учир эрхбиш урьд тогтоол ба хурлын төсөвлөсөн ёсоор болгож зохих газраа мэдүүлэн явуулж батлан тогтоолгох тушаал илгээв. Тус явуулах учир санхүүгийн хэлтсийн өргөсөн нь үүний урьд манай газраас эрхлэх товчоо ба алба аошуудын нэгдүгээр хурлын тогтоолын арван хоёрдугаар зүйлд хэлэлцэж хотын төлөөлөгчдийн нэгдүгээр хуралд шилжүүлэн хэлэлцүүлсэн тогтоолын арван хоёрдугаар зүйлд тус хотын явдлыг захиргааны газраас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Арван хоёр. Мөн хурлын арван хоёрдугаар зүйлд товчооноос тус хотын усан хөөргөний элдэв хэрэгсэл угаас дутуу хагас элэнх үжэрхий болохыг тус газраас бэлтгэн сайжруулахыг чармайн хичээсээр авч эл хэрэгсэл зүйл бүрнээ гүйцэд шинэтгэхүй нь нэн ч хялбаргүй үлэмжхэн тооны мөнгөн хэрэгсэх бөгөөд аливааг нэгэн цагаар гүйцэтгэн хүрэлцүүлэх аргагүй гачигдалтайгаас ийнхүү төлөв хоёр буй нь асар галын аюул дэгдэх ахул ардын амин хөрөнгө хамгаалан гаргаж чадахгүй болгуужин хэмээн тувтан эрмэлзэх авч яахан тус газрын санхүүгийн зүйл нимгэн бөгөөд элдэвт хүрэлцэхгүй маш бэрхтэй үүнд эрж санаваас энэхүү галын аюул хэмээгч хэн этгээдийг нэгэн цагт бүрэлгэн сүйтгэх дайсан мөн болохоор үл барам хот хороог балрагдуулахуйд төдийлөн бэрх хэмээх газаргүй цөм хялбар хэмээвээс болохыг гэр бүр мэдэх хэргийн тулд эл зүйлийг зүй нь тус хотын доторх худалдааны ба энгийн ардаас сайн дурын тусламжийг гаргуулын эвсүүлж тус газрыг элдэв хэрэгслийг бүрэн төгөлдөр сайжруулан гүйцэтгэвээс олон ардын хөрөнгийг сахин хамгаалах хэрэгт тусыг өгч чадах болов уу хэмээвч тогтоолговоос зохих үүнийг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд ийнхүү тусламж эрж туслалцуулах хэмээхүй нь зүйтэй болох тул ёсоор болгон хотын төлөөлөгчий хуралд хэлэлцүүлэн батлуулахаар тогтов хэмээснийг хэлэлцээд тийнхүү тусламж эрэхүйд явдал чирэгдэл үлэмж тулд шууд зогсоож тус хотны доторх дотоод гадаадын олон ардын тус бүрийн үл хөдлөх хөрөнгө зүйлд зохисыг үзэж

татвар онуулан хурааж, гүйцэтгүүлэх явдлыг харьяат захиргааны газраас эрхлэн зохих газраа мэдүүлэн батлуулахаар тогтов.

Арван гурав. Мөн хурлын арван гуравдугаар зүйлд товчооноос тус газрын энэ жилийн бүх орлогын төсөвлөсөн данс ба мөнхүү тус хотын ядуулгыг тэжээн тэнхрүүлэх газрын зарлагын төсөвлөсөн дансны хамт тухайн дүрэм ба байдал төлөвийг баримтлан төсөвлөсөн учраа нийлэлцэх эсэхийг хянан хэлэлцүүлж, тогтоолгоё хэмээснийг зүйл дараалан хянан хэлэлцээд энэ нь төлөв зүйтэй болох тул хотын төлөөлөгчийн хурлаар хэлэлцүүлэн тогтоолгохоор тогтов хэмээснийг хэлэлцээд тус товчооны төсөвлөсөн ба хурлын хянасан нь зүйтэй болох учраа ёсоор болгож зохих газраа мэдүүлэн явуулж батлан тогтоолгох явдлыг захиргааны газраас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Арван дөрөв. Мөн хурлын арван дөрөвдүгээр зүйлд цагдан сэргийлэх хэлтсээс тус газрын хуучин орон савыг зөөн авчирч бариулах эсэхүл тусгай орон сав нэмэн үйлтгүүлэх эсэхийг хэлэлцүүлэе хэмээснийг хэлэлцээд ийнхүү зөөлгөх ба шинэ тувтам үйлтгүүлэхэд энэ удаа хүрэлцэж чадахгүй учраа түтгэлзэн эсэргүүн жилд эрхбиш гүйцэтгүүлэхээр тогтов хэмээснийг хэлэлцээд уг төлөвлөсөн ёсоор болгон гүйцэтгүүлэхээр хэлэлцэн тогтов.

Арван тав. Мөн хурлын арван тавдугаар зүйлд мөнхүү хэлтсээс хуучин цагдан сэргийлэх газрын бурхан шүтээнийг хэрхэх хэмээснийг хэлэлцээд эл бурхан шүтээнийг үрэгдүүлж үл болох тул эдүүгээгийн барьж буй байшинг гүйцмэгц залж ирүүлэн хэвээр хэлтэст тахиулбаас зохих болов уу? хэмээснийг хэлэлцээд шууд шашны хэргийг эрхлэх газраа шилжүүлэн хүргүүлэх явдлыг тус захиргаанаас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Арван зургаа. Мөн хурлын арван зургаадугаар зүйлд мөнхүү хэлтсээс цагдан сэргийлэх газрын хуучин буй хэрэгтэн зорих гяндны хэвээр авчирч барихуйд зай бага пийшин хийлгэж, үл болох балтгар цонхгүй бөгөөд зуны цаг олон хүний амьсгалд бүгчим халуун их төлөв шавраар үйлдсэн агаад алин бүрт тусгүй мэт тул урьд цагдан сэргийлэх газрын төсөвлөсөн гяндангийн маягаар үйлтгүүлбээс болох мэт боловч олон зүйлийг давхцуулан үйлтгүүлэхүйд даанч зардал үлэмждэж, хүрэлцүүлэхэд бэрхтэй газар бүхий тул түүнийг нэгэн дундуураар шинэ тувтам үйлтгүлбээс дахин нэмэвч болох мэт бөгөөд хэрхэхийг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд чингэж шинэ тувтам гяндныг зохисыг үзэж бага хэмжээтэй сайнаар бариульа хэмээхүй нь зүйтэй боловч гагцхүү бас газрын орлого бага барилга үлэмж болох бөгөөд элдвийг хүрэлцүүлэх маш бэрхтэй газар бүхий тул цагдан сэргийлэх газрын улсын санд шилжүүлэх энэ жил нэг сараас таван сар дуусталх орлогын зүйлийг оролцуулан нэмрүүлж дээр дурдсан ёсоор гүйцэтгүүлбээс юу эсэн болов хэмээхийг хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн тогтоолгохоор тогтов хэмээснийг хэлэлцээд уг төлөвлөсөн ёсоор болгож зохих газраа мэдүүлэн явуулж батлан тогтоолгох явдлыг захиргаанаас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Арван долоо. Мөн хурлын арван долоодугаар зүйлд мөнхүү хэлтсээс тус хэлтсийн эрхлэх хэргүүдийг заалгах хэмээсэн нь хэлэлцээд харьяат хэлтэст дагаж шийтгэх тусгай дүрэм зохиолговоос уг эрхлэн шийтгэх элдэв хэргийн заавар аяндаа гарахын дээр ер ч хороо арваны дотор дагаж явах дүрэм зааваргүйд яахил мухардан бүхий байдал илэрхий тул эл

учрыг хамтаар хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн дутаалгаж тусгай комиссыг томилуулан тус тусын дүрэм зааврыг зохиолгын батлуулж дагаж шийтгүүлбээс зохих боловч хэмээх явдлыг хотын хуралд хэлэлцүүлэхээр тогтов хэмээснийг хэлэлцээд эл хэргийн дүрмүүдийг харьяат газраас даруйхнаа төлөвлөж улмаар шүүмжлэн хянан тогтоолгож тухайд зохих газраа мэдүүлэн батлуулах явдлыг захиргаанаас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Арван найм. Мөн хурлын арван наймдугаар зүйлд мөнхүү хэлтсээс цагдан сэргийлэх газраас шилжиж ирсэн морьт цагдаа арван тав явган цагдаа арав, салааны дарга нэг, хуучин албан хааж байсан морьт явган цагдаа тусбүр арав эдний дотроос адил хэрэглэлтэй дарга нэг, аравны дарга хоёр, салааны дарга нэг, туслах дарга нэг, аравны дарга гурав байх бөгөөд туслах дарга аравны дарга нарын хэрэглэл, цагдаа нарын хэрэглэл лугаа нэгэн адил байх тул эл дарга нар байх эсэх хэрвээ байх ахул цалин хэрэглэлийг хэрхэн болгохыг хэлэлцүүлэн болгохыг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд чингэж туслах ба арваны дарга аравны дарга хэмээн байлгахыг хэрэгсэхгүй болгож морьт явган цагдаа нарын нэжгээд салааны дарга суулгаваас зохих үүнд одоо буй морьт цагдаагийн салааны даргын дээр явган цагдаа нарын дотроос чадахыг бодож дөчин таван төгрөгний цалинтай салааны дарга нэгэн орныг сонгон байгуулж, түүний нэмэгдэл цалинг тус газрын төсөвлөсөн дансны нэгдүгээр цалингийн зүйлээс аргацаан тавин олгуулах явдлыг хуралд хэлэлцүүлэхээр тогтов хэмээснийг хэлэлцээд уг төлөвлөсөн ёсоор болгож, гүйцэтгүүлэхээр хэлэлцэн тогтов.

Арван ес. Мөн хурлын арван ёсдүгээр зүйлд мөнхүү хэлтсээс тус газрын цагдаа нарын орон тоо цөөтгөж өдөр шөнийн цаг аливаа харгалзан манах цагдан байцаах зэрэг хэрэгт хүрэлцэхгүй чухлыг алдагдуулахад хүрч бүхий тул хэлхэн болгоохыг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд харьяат цагдаа нарын орон тоо цөөтгөж, аливаад хүрэлцэхгүй хэмээх явдлыг үнэнтэй болох тул хэрхэн болговоос зохихыг хотын хуралд хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд ийнхүү цагдаа нэмэгдүүлэх нь үл зохилдох тул энэ удаа урьд хэвээр явуулж гүйцэтгүүлэхээр хэлэлцэн тогтов.

Хорь. Хурлын хорьдугаар зүйлд мөнхүү хэлтсээс эрхлэн бүхий хэрэг болбоос тус хотын дотор өдөр шөнийн цаг тасралтгүй цагдаж, сэргийлэх гал түймрийг сэргийлүүлэн хамгаалуулах гадаад дотоодын хүн иргэний хулгай худал зарга зальхай өр ширийн зэрэг хэргийг байцаан тодорхойлж зохих газраа шилжүүлэх туслан шийтгэх уг хэрэгт хүлээлгэх зэрэг хэргүүдийг эрхлэн бүхий нь харьяат хэлтсийн түшмэл хэмээгч банди нар орсон эрдэм гүехэн мүжид учирсан ухаан бага боловч тушаалыг хндэтгэн дагаж чадахын чинээгээр цаг хугацаагүй зүтгэсээр буй нь хэрхэн хичээнгүйлбээс хүрэлцэн чадахгүй хилс ял зэмлэлд хүрэх төдийгүй чухлыг алдагдуулан хэргийг удагдуулахуйд хүрсэн тул эрхбиш чадах түшмэдийг томилон авч албан хаалгаж ядуу биднийг хэр чадах албанд зүтгүүлэхийг гүйцэтгэх бөгөөд эл хэргийг хэлэлцүүлэх хэмээснийг хэлэлцээд харьяат хэлтсийн алба хаах түшмэдийн тоог цөөтгөж элдэвт хүрэлцэхгүй боогдуулах хаагдуулахад хүргэж бүхий байдал илэрхий болох үүнд тус хэлтсийн эрхэлсэн түшмэл хоёр орон болох нь даруй тушаал давхардан бүхий бөгөөд нэгэн орныг өөрчлэн мөн газрын комиссаар болгож цалин хэрэглэлийг хэвээр олгох ба байцаагч түшмэл нярав, нэжгээд орныг цалин хэрэглэлийн

хамтаар тусгай нэмэн батлуулж элдэв хэргээс эвлэцүүлэн шийтгэлцүүлбээс энэ удаа хүрэлцэж болох болов уу? хэмээхийг хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн тогтоолгохоор тогтов хэмээснийг хэлэлцээд тус газрын албан хаагчдын энэ удаа нэмэх хэмээхийг хэлэлцэхгүй болгож гагцхүү давхардсан эрхэлсэн түшмэлийн нэгэн орныг туслах болгон явуулж эрхбиш энэ жилд аргацаан гүйцэтгүүлэхээр тогтов.

Хорин нэг. Мөн хурлын нэгдүгээр зүйлд газар түрээсний хэлтсээс хянаваас харьяат хотын доторх гадаадын улсуудад үүний урьд сан аж ахуйн явдлын яамдаас хэмжээлэн зааж орон хашаа байгуулахаар олгосон газрын алтын хэмжээ дээд доодын зэргийн дугаар нь уул дүрэм ба үнэмлэх бичигт нийлэлцэхгүй улиг зөрүү будлиан бүхий бөгөөд түрээс хураах зэрэгт алтнаас хохиролтой зүйл бүхий учир одоо зүй нь эл гадаадын хүмүүсийн урьд авсан газрын будлиан бүхий үнэмлэх бичгүүдийг хураалган тус газраас тувтам шинээр тохиулан шинэчлэн олгож арван зургаадугаар оны хурааваас зохих газрын газрын түрээсийг гүйцэтгэн хурааваас орлого алдагдуулахгүй бөгөөд дүрэм зааварт даруй нийлэлцэх болов уу? хэмээх учрыг илтгэн гаргаж тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд энэ мэт будлиан бүхий зүйлийг дүрэм хэмжээнд нийлүүлэн тухай бүр даруйхнаа шинэчлэн олгуулах зэргээр залруулан гүйцэтгүүлбээс зохих болов уу? хэмээх явдлыг хуралд хэлэлцүүлэхээр тогтов хэмээснийг хэлэлцээд уг төлөвлөсөн ёсоор даруйхнаа залруулан гүйцэтгүүлэхээр тогтов.

Хорин хоёр. Мөн хурлын хорин хоёрдугаар зүйлд тоо бүртгэх салаанаас үүний урьд дээд газруудаас болзоолон тушаасныг дагаж тус хотын доторх бүх хүн амын тоо ба жич гадаадын хүмүүсийн тоог ялган салгаж мэдүүлэхээр харьяат хороодын захирал нарт удаа дараа маяг зааврыг уламжлан хүргүүлж бичиг ба амаар тушааж дахин давтан шаардсаар атал сая зарим хороодоос тус тусын хороодын доторх гадаадын хүмүүсийн дансыг үйлдэж мэдүүлсэн боловч овог язгуурыг ялгаварласангүй ба огт дутагдуулж орхигдуулах зэргээр цөм тушаал учирт үл тохирохоор тодорхойлсон болох учир манай газраас олон хороодын захирал нарыг хуралдуулан чухам яахан чингэж удагдуулан саатуулсан ба уг учир тушаалаас нэгэнт тодорхойлсон орхигдуулсан зэрэг явдлыг нягтлан байцааваас нэр бүхий хороодын захирал нараас тус тусын хүлээлгэсэн албан үүрэгт дахардсаны дээр аливаа гүйцэтгэх явуулах хэргүүд үлэмж ямагт чармайн оролдсоор авч хүрэлцэн чадахгүйгээс иймд хүргүүлбэй. Одоо олох ялыг хүлээвээс өөргүй болсон зэрэг учрыг тус тус харгалзаж мэдүүлсээр бөлгөө гэтэл эдүгээ бас дотоод яамнаас эл хүн хөрөнгийн дансыг эдүгээ хүртэл гүйцэтгэж ирүүлсэнгүй нь гагцхүү хотын захиргааны газраас тушаал зааврыг үл хэрэгсэж, идэвхийлсний харгайгаар улсын тоо бүртгэж, улсын хурал ба намын хуралд оруулах чухал хэргийг шууд саатуулахад хүрвэй хэмээн ам шаардан тушаажээ. Одоо эл чухал хэргийг чухам хэрхэн түргэнээр бүртгэн гүйцэтгэвээс зохих зэргийг хэлэлцүүлэн тогтоолгож гүйцэтгүүлье хэмээснийг хэлэлцээд эл хэргийг ийнхүү удагдуулан саатуулж дутагдуулан мэдүүлсэн явдал үнэн болох бөгөөд үл нийлэлцэх тул зохигчдыг хэрхэн шийтгэж уг хэргийг яахан хурдан түргэнээр гүйцэтгүүлбээс болохыг хотын төлөөлөгчийн хурлаар хэлэлцүүлэн тогтоолгохоор тогтов хэмээснийг хэлэлцээд харьяат захиргааны газраас тэдгээр хороодын захирал төлөөлөгчдийг солилцуулан томилох зэргээр нэн даруйхнаа чангалан тушааж уг дүрэм тушаалын ёсоор гүйцэтгүүлбээс зохимуй хэмээн тогтов.

Хорин гурав. Мөн хурлын хорин гуравдугаар зүйлд товчооноос үүний урьд тусгай комиссыг томилон гаргаж харьяат хотын доторх үл хөдлөх хөрөнгөнд үнэ зохиож мөн ч илүүдэв дутагдав хэмээснийг нь тухай бүр өөрөө хянуулан шийтгүүлж төлөв зүйтэй мэт болсон учраа өнгөрсөн арван тавдугаар оны мөнхүү хүрсний татварын тухайн дүрмийн ёсоор хураахаар зарим хороодод зарлан тушаагаад хураалган бүхий эл зохиосон дансыг хянан хэлэлцүүлж, улмаар хотын хуралд батлуулах хэмээснийг хэлэлцээд энэхүү зохиосон дансны дотор онц хэтрүүлсэн дутагдуулсан зүйл үгүй мэт тул хотын төлөөлөгчийн хуралд явуулан хянан батлуулахаар тогтов хэмээснийг хэлэлцээд тус газрын төлөвлөн зохиосон ба хурлын төлөвлөн хянасан нь төлөв нийлэмжтэй болсон учраа ёсоор болгон батлан тогтов.

Хорин дөрөв. Мөн хурлын хорин дөрөвдүгээр зүйлд товчоо ба үйлдвэрийн хэлтсээс үүний урьд тус захиргааны газрын орон байшинг байгуулахаар төлөвлөсөнд үлэмжхэн мөнгө орох учир тус газрын санхүү нимгэн хүрэлцэхгүй болох тул энэ жилд гарган байгуулж чадахгүй учирт тус тусын тусгай комиссыг томилон гаргаж амгаланбаатар хотын зэрэг газраас хямд хялбар үнэ бүхий арван хоёр зангийн хуучин байшинг худалдан зөөн авсны үнэ ба мөн түүгээр долоон зангийн орос янзтай байшин нэгийг бариулахын хөлстэй нийлж бүгд 3526 төгрөг бас баруун Сэлбийн усыг шуудуулан урсгаж хуучин хоёр гүүрийг ихэтгэн засамжилж байгуулсны үнэ хөлс 4000 төгрөг болсон ба мөн зүүн Сэлбийн хойдох гүүрийг шинэтгэсэн мөн өмнөх гүүрийг засаж сэлбүүлсэнтэйн бүгд үнэ хөлс нийлж 8569 төгрөг болсон үүнд энэ жилийн эл гүүр нь тухайн төсөвлөсөн төгрөг 5000 болохыг тайлаад дутагдах 3569 төгрөгийг дээр дурдсан байшингийн үнэ хөлсний хамтаар нэмэн батлуулах явдлыг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд эл хэргийг зүй нь хотын төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн тогтоолгож гүйцэтгүүлбээс зохихыг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд эл барилгуудыг чингэж бололцох хүрэлцэхийг үзэж хэмнэн гүйцэтгэж буй нь зүйтэй тул зохих газраа явуулан батлуулах явдлыг харьяат захиргаанаас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Хорин тав. Мөн хурлын хорин зургаадугаар зүйлд товчооноос газар түрээсний хэлтсийн эрхэлсэн гишүүн Товуудоржоос хөдөө гэрийн хөгшин ураг өвчтэй бөгөөд надаас өөр сувилах хүн үгүй хэмээн удаа дараа бүрмөсөн чөлөө олгохыг гуйсан тул хэрхэхийг хэлэлцээд тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд чөлөө олгох эсэхийг төлөөлөгчийн хуралд хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд уг асуултын хугацааг тулгуур болсон учраа тухайг үзэж хэлэлцүүлбээс зохимуй хэмэн тогтов.

Хорин зургаа. Товчооноос үүний урьд тус газраас дүрмийн ёсоор харьяат хотын дотор дүрмийн ёсоор харьяат хотын дотор аливаа аян жингийн хүн хөсгийг буудаллуулах газруудыг байгуулан гаргаж алийн хамаа бус гудамжийг хог новш болгох ба самууран будлиатах алдаж осолдох зэргийн гэм нөхцөлийг ариутгаж боловсон зам журамтайд нийлүүлэн явуулахыг эрмэлзэн авч гагцхүү сан хүүгийн нэмснээр элдэв барилгын үйлдвэр боогдох багаад хэрхэн эвсүүлэн гүйцэтгэх явдлыг гарган завдаагүй атал сая аж ахуйн явдлын яамнаас тус захиргааны газраас байгуулахаар төлөвлөн бүхий буудлын дэнг даруйхнаа завдан гүйцэтгэж орлого ашгийн зүйлийг алдагдуулахгүй болгосугай хэмээхээр тушаан хүрс ирсэн үүнд уг газрыг анх байгуулахуйд зардал сүйтгэл үлэмж боловч алсдаа

орлого багагүй үйлдвэр мөний тулд яахан энэ оны аливаа зарлага үлсэн мөнгөний дотроос аргацаан эрхбиш хялбар үнэ бүхий үлэмжхэн орон байшин эрэн худалдан авч засацгаан бэлтгэж чадвал хотын ихээхэн замыг харгалзан хоёр газар тохиолдуулан байгуулж үүсгэн явуулбаас болох эсэх чухам хэрхэн байгуулбаас хүрэлцэж бололцох зэргийг төлөөлөгчдийн хурлаар хянан хэлэлцүүлж тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд чингэж аргацаан гүйцэтгэхийг төлөвлөн буй нь зүйтэй тулд ёсоор болгож даруйхнаа завдах явдлыг харьяат захиргааны газраас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Хорин долоо. Мөнхүү товчооноос эдүгээ дотоод явдлын яамнаас уламжлан сангийн явдлын яамнаас Амгаланбаатар хотын цагдан сэргийлэх хэлтсийн эрхэлсэн түшмэл Цэрэнпунцагийг шилжүүлэн авч алба хаалгах учраа татгалзах эсэхийг хариу ирүүлэхээр тушаасан нь хэрхэхийг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд нэгэнт тушаалд дадаж боловсорсон хүнийг шууд шилжүүлэн уг газрын албаны хэргийг боогдуулахын дээр тэр мэт хүн дав даруй олдож өгтөх нь бэрхтэй тулд харьяат түшмэлийг чингэж шилжүүлж үл болох учрыг хойш явуулж түүгээр өөр томилон гүйцэтгүүлэх явдлыг захиргааны газраас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Хорин найм. Мөн товчооноос харьяат газраас тус хотын зургийг сайнаар зуруулан бэлтгэх хэргийг улирал бүр хичээнгүйлсээр авч тэрхүү тушаал хүний цалин бага агаад боловсронгуй хүн тохирч олдохгүйгээс боогдон гачигдсаар эдүгээд хүрсэн энэ нь аль бүрт үл нийлэлцэх үүнд тэрхүү хэмжээ авч зураг үйлдэх тушаалын хүмүүсийн цалингийн нэгэн жилийн зардал мөнгөнөөс хэтрүүлэхгүйгээр үнэ хөлс гаргаж зохих чадах хүн лугаа хэлэлцэн тусгай гэрээ байгуулан батлуулж завдан гүйцэтгүүлбээс нийлэлцэх эсэхийг хэлэлцүүлэн тогтоолгоё хэмээснийг хэлэлцээд чингэж зургийг чухалчлан үйлтгүүлэх нь зүйтэй тулд уг төлөвлөсөн ёсоор даруйхнаа сайн чадах үнэнч боловсронгуй хүн лүгээ хэлэлцэн тогтож гэрээ байгуулж гүйцэтгүүлэх явдлыг харьяат захиргааны газраас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов.

Хурлан дарга Дарьжав

Дэд дарга Батсүх

Нарийн бичгийн дарга Мишигдорж